



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 08 одер

Дугаар 1/415

Чойбалсан

Г

Комисс байгуулах тухай

Т

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, Авто замын тухай хуулийн 28 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 49 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03/04 дүгээр тогтоол, зохиогч, захиалагчийн хяналт хийсэн тайлан, дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Авто замын сангийн 2025 оны хөрөнгө оруулалтаар "Тэгш уудам харгүй" ХХК-ийн гүйцэтгэсэн "Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийн засвар, арчлалт" ажлын 3 дугаар багц "Чойбалсангийн гудамж "Дорнод НАА" ОНӨААТҮГ-ын зүүн талын босоо тэнхлэгийн авто замын арчлалт"-ын ажлыг хүлээн авах, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: А.Түмэнжаргал

-Аймгийн Ерөнхий архитектор

Гишүүд:

Т.Баярмаа

-Аймгийн Архивын хэлтсийн
Сан хөмрөгч

М.Ганбат

-Аймгийн Засаг даргын тамгын
газрын Авто замын хяналтын
улсын байцаагч

М.Гансүмбэр

-Аймгийн Орон нутгийн өмчийн
газрын мэргэжилтэн

Х.Батсайхан

-Аймгийн Цагдаагийн газрын
Замын цагдаагийн тасгийн
дарга, хошууч

Ч.Алтансувд

-Чойбалсан хотын Захирагчийн
албаны даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч

Х.Хүрэлбаатар

-Зураг төслийн байгууллагын
төлөөлөл, ХЭТ-Авто зам"
ХХК-ийн захирал

Г.Оюунбаатар

-Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл, "Тэгш уудам харгуй" ХХК-ийн захирал

Комиссын нарийн бичиг:

Б.Урансүх

-Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Комиссын үйл ажиллагааг Засгийн газрын 2018 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу "Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийн засвар, арчлалт" ажлын 3 дугаар багц "Чойбалсангийн гудамж "Дорнод НАА" ОНӨААТҮГ-ын зүүн талын босоо тэнхлэгийн авто замын арчлалт"-ын ажлыг удирдан зохион байгуулж, ажлын дүгнэлтийг аймгийн Засаг даргад урьдчилан танилцуулсны дараа албан ёсоор баталгаажуулахыг Комиссын дарга (А.Түмэнжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ш.ЁЛ

